



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/257

Булган сум

### Мэргэжлийн анги байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.10 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 тоот тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймаг, сумын нутаг дэвсгэрт болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын болон тусгай зориулалтын мэргэжлийн ангийг төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагыг түшиглэн 1 дүгээр, мэргэжлийн ангийн нийтлэг чиг үүргийг 2 дугаар, мэргэжлийн ангийн бүтцийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тухайн шатны Засаг дарга, төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь эрхэлсэн салбарынхаа хэмжээнд үйл ажиллагаатайгаа уялдуулан мэргэжлийн анги, удирдах бүрэлдэхүүнийг байгуулж, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр ханган, бэлтгэл бэлэн байдлыг тогтвортой хангаж ажиллахыг дарга, захирал нарт, биелэлтэд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөмж, удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ш.Баасандорж)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/217 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
 ОН дүгээр сарын 14-ны өдрийн А/25 дугаар  
 захирамжийн 1 дүгээр хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН  
 МЭРГЭЖЛИЙН АНГИ

Д/д	Мэргэжлийн анги	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага, аж ахуйн нэгж,
1	2	3	4
1	Эрүүл мэндийн мэргэжлийн анги	Нэгдсэн эмнэлэг	-----
2	Нийгмийн хамгааллын мэргэжлийн анги	БШУГазар	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар,
3	Хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн анги	Улсын нөөц хүмүүнлэгийн тусламжийн анги,	“Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй” ОНӨХХК, Улаан загалмайн хороо
4	Хэв журам сахиулах, тусгай ажиллагааны мэргэжлийн анги	Цагдаагийн газар	“ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтэс
5	Санхүү нөөц хангалтын мэргэжлийн анги	Санхүү, төрийн сангийн хэлтэс,	МСҮТ, ХАА-н МСҮТ, 1,3-р 12 жилийн сургууль, ЭӨЦС, Спортын дунд сургууль, “Баясуулагч” зах “Магнай трейд”, “НИК-Петровис”, “Шунхлай”, “Тэс”, “Сод Монгол”, “ЮниГаз” ШТС-ын Булган сум дахь салбарууд
6	Нүүлгэн шилжүүлэлт, түр байрны мэргэжлийн анги	Авто тээврийн үндэсний төвийн Булган аймаг дахь салбар	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Булган сум,
7	Хоргодох байрны мэргэжлийн анги	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	-----
8	Хүнс, хөдөө аж ахуйн мэргэжлийн анги	Хүнс, хөдөө аж ахуйн газар	-----
9	Ус хамгааллын мэргэжлийн анги	Байгаль орчин, аялал жуулчлалын газар,	Дулаан, ус хангамжийн Булган-Мээж ОНӨХХК, Хүнс, хөдөө аж ахуйн газар
10	Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн анги	Мал эмнэлгийн газар	-----
11	Гал унтраах мэргэжлийн анги	Гал түймэр унтраах, аврах 20 дугаар анги	Булган сум
12	Цахилгаан шугам сүлжээний засварын мэргэжлийн анги	Эрдэнэт-Булган ЦТСТӨХК	-----
13	Зам, гүүр засварын мэргэжлийн анги	Булган-АЗЗА	-----
14	Дулааны шугам сүлжээний засварын мэргэжлийн анги	Дулаан, ус хангамжийн Булган-Мээж ОНӨХХК	-----

15	Харилцаа, холбоо зарлан мэдээллийн мэргэжлийн анги	“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ний Булган аймгийн газар	Үүрэн холбооны операторууд
16	Иргэний бүртгэл, мэдээлэл, статистикийн мэргэжлийн анги	Улсын бүртгэлийн хэлтэс	Статистикийн хэлтэс
17	Цацраг, химийн хяналтын мэргэжлийн анги	Ус, цаг уур орчны шинжилгээний газар	Стандарт, хэмжил зүйн хэлтэс
18	Нисэх буудлын аюулгүй байдлын мэргэжлийн анги	ИНЕГ-ын харьяа Булган аймаг дахь нисэх буудал	-----
19	Мэдээлэл сурталчилгааны мэргэжлийн анги	Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах алба	Сайхан-Монгол” телевиз
20	Хуулийн этгээдийн мэргэжлийн анги	Булган сум	Улаан загалмайн нийгэмлэг, МСҮТ, ХАА-н МСҮТ,



Аймгийн Засаг даргын 2023 оны  
 04 дүгээр сарын 07-ны өдрийн АЗС-дугаар  
 захирамжийн 2 дугаар хавсралт



ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН  
 АНГИЙН ЧИГ ҮҮРЭГ

Д/д	Мэргэжлийн ангийн зориулалт	Мэргэжлийн ангийн ангилал	Тухайн мэргэжлийн ангийн чиг үүрэг
1	2	3	4
1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Яаралтай тусламжийн бүлэг	Гамшгийн голомтод нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилж, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлэгт тээвэрлэн хүргэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах
		Хээрийн эмнэлэг	Хээрийн нөхцөлд нэрвэгдэгсдэд эмнэлгийн шаардлагатай бүхий л төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэл зүйн лабораторийн шинжилгээ хийх, өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах
		Цус элбэх хөдөлгөөнт бүлэг	Нэрвэгдэгсдийг цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээгээр хангах, нөөц бүрдүүлэх, тээвэрлэх, хүргэх ажлыг зохион байгуулах
		Эм, эмнэлгийн хэрэгслээр хангах бүлэг	Гамшиг, ослын үед хээрийн эмнэлэг болон яаралтай тусламжийн хэсгийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, хээрийн нөхцөлд хөдөлгөөнт эмийн сан ажиллуулах
		Зоонозын өвчинтэй тэмцэх бүлэг	Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, голомтыг цомхотгож хор уршгийг арилгах зорилгоор эмчлэн тусгаарлах, хавьтлыг тогтоож хяналтад авах, ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг хариу арга хэмжээ авах
		Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг	Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн анхны тусламж, дэмжлэг үзүүлэх, гамшгийн дараах стрессийг бууруулах, сэтгэл гутралыг багасгах, хүмүүсийн даван туулах итгэл найдварыг сэргээх, бусадтай харилцах, холбоо тогтооход нь туслах. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн эрэн хайх, аврах ажиллагааны багийн гишүүдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх
2	Нийгмийн хамгаалал	Хүүхэд хамгаалал, боловсролын бүлэг	Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохионбайгуулах
		Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах бүлэг	Гамшиг, ослын үед өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн асуудлыг зохион байгуулах, голомтын бүсээс эхний ээлжинд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах

3	Хүмүүнлэгийн тусламж	Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бүлэг	Нэрвэгдэгсдэд холбогдох дүрэм, журмын дагуу дотоодын нөөцөөс хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах
		Олон Улсын хүмүүнлэгийн тусламжийн бүлэг	Гамшигийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн Олон Улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах
4	Хэв журам сахиулах ажиллагаа	Хэв журам сахиулах бүлэг	Гамшиг, ослын үед нийгмийн хэв журам сахиулах, эрэн хайх, аврах ажиллагаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорио цээрийн дэглэмийн үеийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах зэрэг бусад хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд ажиллах
		Тусгай бүлэг	Терроризмтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих, ухуулга, сурталчилгаа хийх
5	Санхүү, нөөц, хангалт	Санхүү, нөөцийн бүлэг	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр нөөц хөрөнгө бүрдүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шаардлагатай мөнгөн хөрөнгө, зардлыг тооцох, шийдвэрлүүлэх гамшиг,ослын үед шаардагдах төрөл бүрийн хангалтын нөөцийг холбогдох норм, стандартын дагуу бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, сэлгэх ажлыг зохион байгуулах, хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн ангитай хамтран нөөцийн бараа бүтээгдэхүүнийг хуваарилах ажлыг зохион байгуулах
		Хүнсний хангалтын бүлэг	Нэрвэгдэгсэд болон гамшиг, ослын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг ус, хоол, хүнсээр хангах
		Орон байр, хувцас хангалтын бүлэг	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсэд болон аврагч, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа иргэдийн хэрэгцээг тодорхойлж, орон байр, дулаан хувцас, хөнжил, гудас зэргээр хангах
		Тээврийн бүлэг	Нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшиг, ослын голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээ үзүүлэх
		Шатахуун, хийн түлш хангалтын бүлэг	Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэж байгаа автомашин, бусад техник хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх, хангах, нөөц бүрдүүлэх
6	Нүүлгэн шилжүүлэлт, түр байр	Нүүлгэн шилжүүлэлтт үр байрны бүлэг	Гамшиг, ослын голомтоос нүүлгэн шилжүүлэх, түр байр дэлгэж иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээ (орон байр, цэвэр ус, хоол хүнс, хөнжил, дулаан хувцас, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, аюулгүй байдал)-г хангах арга хэмжээг зохион байгуулах
7	Хоргодох		Гамшиг, ослын /хүчтэй шуурга, цацраг, хими биологийн



	байр	Хоргодох байрны бүлэг	аюул/ үед хүн амыг түр байрлуулах хоргодох байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах
8	Хүнс, хөдөө аж ахуй	Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн бүлэг	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, халдварын голомт дахь мал, амьтанд үзлэг тандалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хорио цээрийн дэглэм тогтоох, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу авч хэрэгжүүлэх
		Ургамал, газар тариалан хамгаалах бүлэг	Химийн хоргүй, байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга технологиор бэлчээрийн болон тариалангийн талбайд хөнөөл учруулдаг хортон шавьж, мэрэгчдийн тархалттай тэмцэх, үрийн агуулах, техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдал, стандартын шаардлагыг хангуулах
		Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүлэг	Мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, цацраг идэвхт болон химийн хорт бодисоор хордсон талбай, халдварт өвчний голомт, голомтод байсан хүн, техник хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ хийх
9	Гал түймэр унтраах ажиллагаа	Гал түймэр унтраах бүлэг	Объектын болон ой, хээрийн түймрээс хүний амь нас, эд хөрөнгө, байгалийн баялагийг авран хамгаалах, гал түймрийг унтраах ажлыг зохион байгуулах
10	Усны сан бүхий газар, уст цэг хамгаалах ажиллагаа	Цэвэр, бохир усны засварын бүлэг	Цэвэр, бохир усны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босгох ажил гүйцэтгэх
		Уст цэг хамгаалах бүлэг	Усны эх ундарга, усны сан бүхий газар, уст цэгийн бохирдолтод шинжилгээ хийх, усыг бохирдох, хор, халдвараас хамгаалах, ариутгал хийх, шинээр худаг ус гаргах, ус тээвэрлэх, түгээх, харуул хамгаалалтад авах, үер усны аюулаас хамгаалах
11	Дулаан хангамж	Дулааны шугам сүлжээний засварын бүлэг	Дулааны эрчим хүчний системийн аюулгүй ажиллагааг хангах, шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг илрүүлэх, засвар үйлчилгээ хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
12	Цахилгаан хангамж	Цахилгаан, шугамсүлжээний засварын бүлэг	Гаймшиг, ослын үед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц, шугаманд гарсан эвдрэл гэмтлийг засварлах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
13	Зам, гүүрийн засвар, үйлчилгээ	Зам, гүүрийн засварын бүлэг	Гамшиг, ослын улмаас нурсан, эвдэрсэн зам, гүүрт засвар хийх, гарц гаргах, түр гүүр тавих, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
14	Инженер, тэсэлгээ	Инженер, тэсэлгээний бүлэг	Аврах ажиллагаа зохион байгуулахад учирч буй саадыг арилгах зорилгоор тэсэлгээний ажлыг зохих журмын дагуу аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэх. (цасны нуранги, мөснийхахаа зайлуулах, нурангинд дарагдсан зам гарцыг чөлөөлөх гэх мэт)

15	Цацраг, химийн хяналт	Цацраг, химийн хяналтын бүлэг	Гамшиг, ослын голомтод цацраг, химийн тандалт явуулах, үнэлэлт өгөх, цацрагийн түвшингийн хэмжилт хийх, эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, саармагжуулах ба идэвхгүйжүүлэх, ариутгал цэвэрлэгээ хийх
16	Харилцаа холбоо, зарлан мэдээлэл	Харилцаа холбоо, зарлан мэдээллийн бүлэг	Гамшиг, ослын үед Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, гамшгаас хамгаалах алба, штаб, шуурхай бүлгийн удирдлагын байр, мэргэжлийн ангийг найдвартай холбоогоор хангах, холбооны шугамд гарсан гэмтлийг засварлах, сэргээн босгох, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, холбогдох албан тушаалтны шийдвэрээр харьяа нутаг дэвсгэртээ зарлан мэдээлэл дамжуулах
17	Мэдээлэл, сурталчилгаа	Мэдээлэл, сурталчилгааны бүлэг	Гамшиг, ослын нөхцөл байдлын талаарх бодит мэдээллээр хангах, гамшгийн үед иргэдэд ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах
18	Иргэний бүртгэл мэдээлэл, статистик судалгаа	Иргэний бүртгэл, мэдээллийн бүлэг	Гамшиг, ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргаж өгөх
		Статистик мэдээллийн бүлэг	Мал амьтан, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, хүч хэрэгслийн тооцоо судалгаа гаргах
19	Төмөр замын засвар, үйлчилгээ	Төмөр замын засварын бүлэг	Төмөр замын ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед аврах ажиллагаа зохион байгуулах, галт тэрэгний хөдөлгөөнийг сэргээх, мэргэжлийн бусад ажлуудыг гүйцэтгэх
20	Нисэх буудлын аюулгүй байдал	Нисэх буудлын аюулгүй байдлын бүлэг	Агаарын хөлгийн хөөрөх, буух үеийн аюулгүй байдлыг хангуулах, гамшиг, ослын үед нислэгийн бүсэд аврах, хор уршгийг арилгах, гал түймрийг унтраах, нийслэгийн зурвасыг сэргээн босгох ажлыг зохион байгуулах
21	Хуулийн этгээдийн мэргэжлийн анги	Анхны тусламжийн нөхөрлөл	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд анхны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх
		Аврах, гал унтраах бүлэг	Гамшиг, ослын үед эрэн хайх, аврах, гал түймэр унтраах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
		Ухуулга, сурталчилгааны бүлэг	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулах



**МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮТЭЦ**  
 Ерөнхий зориулалтын мэргэжлийн анги

Сум, дүүргийн ерөнхий зориулалтын  
 мэргэжлийн анги  
 Дарга

Орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа  
 хариуцсан ажилтан

Аюулгүй байдал хариуцсан  
 ажилтан

Холбоо хариуцсан ажилтан

Хангалт хариуцсан ажилтан

**Гал түймэр унтраах, эрэн  
 хайх аврах бүлэг**  
**Орон тоо: 23**  
 -Бүлгийн дарга  
 -Аврагч  
**Техник, багаж, хэрэгсэл:**  
 -Суудлын авто машин  
 -Ачааны авто машин  
 -Зөөлөн холбоо  
 -Хүрз  
 -Сүх  
 -Хөрөө  
 -Малтуур  
 -Троссон шүүр  
 -Галын хор  
 -РЛО  
 -Үлээгч аппарат  
 -Аврах шат  
 -Аврах орс  
 -Өргөгч  
 -Дамнуурга  
 -Дэгээ  
 -Аврах хоолой  
 -Аврах дэвсгэр

**Механикуулсан бүлэг**  
**Орон тоо: 8**  
 -Хэсгийн ахлагч  
 -Гагнуурчин  
 -Цахилгаанчин  
 -Сантехникийн слесарь  
 -Компрессорчин  
 -Бульдозерчин  
 -Экскаваторчин  
 -Жолооч  
**Техник, багаж, хэрэгсэл:**  
 -Ачааны авто машин  
 -Өрөө буулгагч  
 -Экскаватор  
 -Бульдозер  
 -Цистерн  
 -Гагнуурын иж бүрдэл  
 -Цахилгааны багаж  
 -Компрессор  
 -Сантехникийн багаж

**Эрүүл мэндийн бүлэг**  
**Орон тоо: 8**  
 -Бүлгийн ахлагч  
 -Их эмч  
 -Сувилагч  
 -Жолооч  
**Техник, багаж, хэрэгсэл:**  
 -Авто машин  
 -Эмнэлгийн хэрэгсэл  
 -Шаардлагатай багаж  
 төхөөрөмж

**Хэв журам сахиулах бүлэг**  
**Орон тоо: 8**  
 -Бүлгийн ахлагч  
 -Офицер  
 -Цагдаа  
**Техник, багаж, хэрэгсэл:**  
 -Авто машин  
 -Чанга яригч  
 -Шаардлагатай багаж  
 төхөөрөмж


**Анхны тусламжийн бүлэг**  
**Орон тоо: 16**  
 -Дарга  
 -Ухуулагч  
 -Жолооч  
 -Холбоочин  
 -Идэвхитэн  
**Техник, багаж, хэрэгсэл:**  
 -Ачааны авто машин  
 -Дамнуурга  
 -Анхны тусламжийн иж  
 бүрдэл хүн нэг бүрт

Бусад

Тайлбар: Сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги  
 66-аас доошгүй, Дүүргийн ерөнхий зориулалтын  
 мэргэжлийн анги 90-аас доошгүй орон тоотой байна.



# Тусгай зориулалтын мэргэжлийн анги



Нийгмийн хамгааллын мэргэжлийн анги  
Дарга

Орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан

Аюулгүй байдал хариуцсан ажилтан

Холбоо хариуцсан ажилтан

Хангалт хариуцсан ажилтан

Хүүхэд хамгаалах, боловсролын бүлэг

Орон тоо:  
-Бүлгийн ахлагч  
-Багш  
-Сэтгэлзүйч  
-Хүмүүнлэгийн ажилтан  
-Жолооч  
Техник, багаж, хэрэгсэл:  
-Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд шаардлагатай зүйлс  
-Сурах орчинд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл  
-Автомашин


Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах бүлэг

Орон тоо:  
-Бүлгийн ахлагч  
-Халамжийн ажилтан  
-Хүмүүнлэгийн ажилтан  
-Эмч  
-Сувилагч  
-Жолооч  
Техник, багаж, хэрэгсэл:  
-Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай хэрэгслүүд  
-Автомашин

Сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх бүлэг



Орон тоо:  
-Бүлгийн ахлагч  
-Сэтгэл судлаач  
-Сэтгэлзүйч  
-Хүмүүнлэгийн ажилтан  
-Жолооч  
Техник, багаж, хэрэгсэл:  
-Сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай материал хэрэгсэл  
-Автомашин






- Орон тоо:
- Бүлгийн ахлагч
  - Нярав
  - Туслах ажилтан
  - Хүмүүнлэгийн ажилтан
  - Жолооч
- Техник, багаж, хэрэгсэл:
- Орон байр
  - Ус, хүнс
  - Хувцас хэрэгсэл
  - Анхны тусламжийн иж бүрдэл
  - Автомашин

- Орон тоо:
- Бүлгийн ахлагч
  - Нярав
  - Олон Улсын хүмүүнлэгийн ажилтан
  - Орчуулагч
  - Туслах ажилтан
  - Хүмүүнлэгийн ажилтан
  - Жолооч
- Техник, багаж, хэрэгсэл:
- Орон байр
  - Ус, хүнс
  - Хувцас хэрэгсэл
  - Анхны тусламжийн иж бүрдэл
  - Автомашин








Нүүлгэн шилжүүлэлт, түр байрны  
мэргэжлийн анги  
Дарга

Орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа  
хариуцсан ажилтан


Хангалт хариуцсан ажилтан


Холбоо хариуцсан ажилтан


Аюулгүй байдал хариуцсан  
ажилтан











Ус хамгааллын мэргэжлийн анги

Дарга

Орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан

Аюулгүй байдал хариуцсан ажилтан

Холбоо хариуцсан ажилтан

Хангалт хариуцсан ажилтан

Цэвэр бохир усны засварын бүлэг

Уст цэг хамгаалах бүлэг


Орон тоо:

- Булгийн ахлагч
  - Слесарь
  - Цахилгаан гагнуурчин
  - Хийн гагнуурчин
- Техник, багаж, хэрэгсэл:
- Сантехникийн багаж
  - Цахилгаан гагнуурын иж бүрдэл
  - Хийн гагнуурын иж бүрдэл
  - Ус сорогч /Мотопомп/
  - Гэрэлтүүлгийн үүсгүүр
  - Худгийн өрмийн машин гэх мэт

Орон тоо:

- Хамгаалалтын албаны дарга
  - Хамгаалагч
- Техник, багаж, хэрэгсэл:
- Радио станц, үүрэн телефон
  - Хамгаалалтын тусгай хэрэгсэл
  - Геофизикийн багаж
  - Шардлагатай багаж төхөөрөмж





Дулааны шугам сүлжээний засварын мэргэжлийн анги

Дарга

Орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан

Аюулгүй байдал хариуцсан ажилтан

Холбоо хариуцсан ажилтан

Хангалт хариуцсан ажилтан

Дулааны шугмын бүлэг

Техникийн бүлэг

Хангалтын бүлэг

Орон тоо:  
-Хэсгийн ахлагч  
-Слесарь  
-Цахилгаан гагнуурчин  
-Хийн гагнуурчин  
Техник, багаж, хэрэгсэл:  
-Сантехникийн багаж  
-Цахилгаан гагнуурын иж бүрдэл  
-Хийн гагнуурын иж бүрдэл  
-Мотопомп  
-Цахилгаан үүсгүүр

Орон тоо:  
-Хэсгийн ахлагч, инженер  
-Жолооч кранчин  
-Оосорлогч  
-Дохиочин  
-Компрессорын машинист  
-Жолооч засварчин  
-Жолооч  
Техник, багаж, хэрэгсэл:  
-Авто өгрөгч  
-Эксковатор  
-Компрессор  
-Тусгай зориулалтын засварын машин  
-Ачааны машин

Орон тоо:  
-Материал, хэрэгслийн хангалт хариуцсан мэргэжилтэн  
-Жолооч  
Техник, багаж, хэрэгсэл:  
-Суудлын авто машин  
-Ачааны машин

